



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит  
нийслэлийн аварга шалгаруулах цэрэг-спортын  
“Дөл” цогцолбор тэмцээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/297 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний хоёрдугаар шатны шалгаруулалтаас тэргүүн байранд шалгарсан тасгийн шилдэг тамирчдыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 17-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 084 ангийн байрлал болон тус ангийн сургалтын төвийн байрлалд байрлуулсан, нийслэлийн Засаг даргын нэрэмжит нийслэлийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” тэмцээнд оролцох бэлтгэлийг хангуулж, оролцуулсугай.

2. Тэмцээнд оролцох дасгалжуулагч, тамирчдын аюулгүй арга хэмжээг сахиулж, удирдлага арга зүйгээр ханган, амжилттай бэлтгэн оролцуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа Б.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Тэмцээний бэлтгэлийг хангаж, оролцуулахад шаардагдах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ